



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Сайншанд сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн
тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/73/СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.dornogovi.audit.mn

Дорноговь аймаг
2020 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 70522734 Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Энхцэцэг

Утас: 70523020 Цахим хаяг: enkhtsetseg.e@audit.gov.mn

Аудитор: Л.Равдандорж

Цахим хаяг: ravdandorjl@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
Менежментийн захидал	11
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	12
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	14
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	16
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	18
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	19
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	21


**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

САЙНШАНД СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Г.ТУНГАЛАГТУЯА ТАНАА

2020.02.28 № 1-6/129
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сайншанд сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Сайншанд сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Сайншанд сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Сайншанд сумын Засаг даргын Тамгын газар Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2.1. Оршил

Сайншанд сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Сайншанд сумын ЗДТГ-ын дарга Г.Тунгалагтуяа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй, болгох зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сайншанд сумын ЗДТГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сайншанд сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 05-аас 2020 оны 02 дугаар сарын 11-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Равдандорж хариуцаж хэрэгжүүлэв.

Сайншанд сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 02 дүгээр сарын 04-ний өдрийн 3/123 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Сайншанд сумын ЗДТГ-ын үйл ажиллагааны эрхэм зорилго нь Хүний хөгжлийг дээдэлсэн, амьдрах таатай орчин бүрдүүлсэн, байгаль, орчинд ээлтэй аж үйлдвэрлэл, аялал жуулчлалаар тэргүүлэгч, эдийн засгийн өндөр чадвартай, хөгжлийн тулгуур хот болох гэсэн эрхэм зорилго дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Сайншанд сумын ЗДТГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн үйл ажиллагааг иргэдэд түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Сайншанд сумын ЗДТГ нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Сайншанд сумын ЗДТГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Сайншанд сумын ЗДТГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 31 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 2,316,817.9 мянган төгрөгөөс тооцон 23,168.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 23,168.2 мянган төгрөгөөр тооцсон нь нийт зардлын 1 хувиас давсан алдааг материаллаг алдаа гэж үзсэнтэй холбоотой.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Сайншанд сумын ЗДТГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 575,371.4 мянган төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	13,959.8	10,929.8	-3,029.9
Авлага	435.6	31,641.4	31,205.8
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	177,430.6	201,898.2	24,467.7
Үндсэн хөрөнгө	7,484,632.2	6,856,617.3	-628,014.9
Нийт хөрөнгө	7,683,378.2	7,108,006.8	-575,371.4
Өр төлбөр	0.0	3,331.5	3,331.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	7,683,378.2	7,104,675.2	-578,702.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	7,683,378.2	7,108,006.8	-575,371.4

Авлага дансны үлдэгдэл өссөн нь 31,641.4 мянган төгрөгөөр нэмэгдэж 435.6 мянган төгрөгөөр хасагдсан нь нэмэлт дансны үлдэгдлийг орон нутагт төвлөрүүлж авлагаар тусгаснаас шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь тайлант хугацаанд 536,292.4 мянган төгрөгийн бараа материал бэлтгэж, 511,824.7 мянган төгрөгийн материалыг зарцуулсан нь нөлөөлжээ.

Үндсэн хөрөнгийн дансанд өөрийн хөрөнгөөр 8,831.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн. Үнэ төлбөргүйгээр аймгийн ИТХ-ын 2019 оны 74 дүгээр тогтоолоор 72,126.1 мянган төгрөг, Замын сангийн хөрөнгө оруулалтаар 61,919.5 мянган төгрөг, Сайншанд сумын ОНХСангийн хөрөнгө оруулалтаар 10,101.0 мянган төгрөг, аймгийн ИТХ-ын 13 дугаар тогтоолоор 8,573.2 мянган төгрөг нийт 161,550.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө шилжүүлэн авсан. Аймгийн ИТХ-ын 2019 оны 74 дүгээр тогтоолоор Сайншанд Хот тохижилтын газарт 154,919.4 мянган төгрөгийн барилга, шугам, хашааг үнэ төлбөргүй шилжүүлсэн, 25,735.1 мянган төгрөгийн хөрөнгө акталсан. Хөрөнгийн хөдөлгөөнд орсон 608,911.2 мянган төгрөгийн элэгдэл хорогдол нь үндсэн хөрөнгө буурахад шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 7,104,675.2 мянган төгрөг болж 578,702.9 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгө шилжүүлсэн, акталсан мөн элэгдэл хорогдол шалтгаалжээ.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 1,011,948.9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 987,012.6 мянган төгрөгийг урсгал зардалд, 24,936.3 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,010,948.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын 1,011,948.9 мянган төгрөгөөр баталж гүйцэтгэл 998,397.9 мянган төгрөг буюу 98.66 хувьтай байгаа нь төсвийн төлөвлөлтийг сайн хийснээс шалтгаалсан байна.

Нэмэлт төсөв: Аймгийн ЗДТГ-с 8,500.0 мянган төгрөг, аймгийн ИТХ-с 29,206.7 мянган төгрөг, Байгаль орчны газраас 60,000.0 мянган төгрөг, Онцгой байдлын газраас 31,109.9 мянган төгрөг, нийт 128,816.6 мянга төгрөгийг дээд шатны төсөв захирагчаас, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 4,117.5 мянган төгрөг, нийт 132,934.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Үүнээс шилдэг сумын шагнал 1,500.0 мянган төгрөг, долоон багийн ахмадуудад хүндэтгэл үзүүлэх өдөрт зориулж 7,000.0 мянган төгрөг, олон нийтийн цагдаагийн урамшуулал 29,277.4 мянган төгрөг, Онцгой байдлын газраас 2017-2018 оны нөхөн олговор, томилолтын зардалд 31,109.9 мянган төгрөг, мал тооллогын шатахууны зардалд 444.3 мянган төгрөг, бүртгэл мэдээллийн ажилтны урамшуулалд 1,890.0 мянган төгрөг, Дэлгэр баясах зам ХХК-д нөхөн сэргээлтийн зардалд 30,000.0 мянган төгрөг, бусад үйл ажиллагаанд 31,712.5 мянган төгрөгийг зарцуулж, дансны үлдэгдэл 31,641.4 мянган төгрөгийн үлдэгдлийг төсөвт төвлөрүүлсэн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 31 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 6 эрсдэл тодорхойлж нийт 6 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 41,389.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 32,518.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 229.1 мянган төгрөгийн зөрчилд 2 акт, 8,109.4 мянган төгрөгийн 2 албан шаардлага тогтоож, 531.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 8,870.1 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 8,109.4 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, албан шаардлага хүргүүлээ.

Үүнд:

1. Илүү тооцож олгосон цалин нь Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.5.5 дахь заалт *“Төсвийн шууд захирагчийн батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”* үүрэгтэй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.2.5 дахь заалт *“Нягтлан бодогч нь дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах үүрэгтэй”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

2. Бүрдэл болоогүй анхан шатны баримтыг үндэслэн олгосон томилолт нь Үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дахь заалт *“Нягтлан бодогч хуурамч баримт бүрдүүлэн ажил гүйлгээг дансанд бичихийг хориглоно”* гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

3. Цалинг зөрүүтэй тооцож суутгасан нь Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.2.5 дахь заалт *“Нягтлан бодогч нь дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах үүрэгтэй”* гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага тогтоосон.

4. Эд хариуцагч шатахууны зарцуулалтын анхан шатны баримтыг үндэслэж тайлагнаагүй, НББ-д тусгалгүй орхигдуулсан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.2.6 дахь заалт *“Нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах үүрэгтэй”* Сангийн сайдын 2000 оны 69 дүгээр тушаалын 2 дугаар зүйл 2.10 дахь заалт *“Эд хариуцагч нь өөрийн хариуцаж байгаа зүйлийн орлого, зарлагын болон үлдэгдлийн мэдээ тайланг тухай бүр зохих маягтаар хариуцсан нягтлан бодогчид гаргаж өгч байна”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага тогтоосон.

Аудитаар илэрсэн 531.6 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Цалингийн хавтгайд бодогдож байгаа цалинг нийгмийн даатгал, татварын тайлантай тулган үзэх, мөн Засаг даргын захирамжаар зарцуулагдаж байгаа ажил үйлчилгээний хэрэгжилтийн тайлан, гүйцэтгэлийг хянаж үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 145 мэдээллийг хугацаанд нь, 11 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Нийт 3 зөвлөмж өгснөөс 3 зөвлөмжийг хэрэгжүүлж 100 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Сайншанд сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Сайншанд сумын ЗДТГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал.

1.1. Илрүүлэлт: Цалинг олгосон хүснэгтийн тооцооллоос нийгмийн даатгалын тайлангаарх шимтгэлийн дүн 531.6 мянган төгрөгөөр зөрүүтэй.

1.2. Эрсдэл: Нягтлан бодох бүртгэлийг алдаатай хөтлөх, төсөвт өглөг, авлага үүсгэх.

1.3. Өгсөн зөвлөмж: Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн тооцооллыг цалингийн програмын бодолттой тулгаж тайлагнах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Тооцооллыг шалгаж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>198,745,932.70</u>	<u>251,389,452.70</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	13,959,757.00	10,929,827.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	13,959,757.00	10,929,827.00
3121	Төгрөг	13,959,757.00	10,929,827.00
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	13,959,757.00	10,929,827.00
33	АВЛАГА	435,600.00	31,641,389.00
335	Бусад авлага	435,600.00	31,641,389.00
3351	Байгууллагаас авах авлага	435,600.00	31,641,389.00
34	УРЬДЧИЛГАА	6,920,000.00	6,920,000.00
3471	Урьдчилгаа тооцоо	6,920,000.00	6,920,000.00
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	6,920,000.00	6,920,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	177,430,575.70	201,898,236.70
351	Түүхий эд материал	101,848,913.50	101,848,913.50
35110	Тусгай зориулалттай материал	101,848,913.50	101,848,913.50
354	Хангамжийн материал	75,581,662.20	100,049,323.20
35410	Бичиг хэргийн материал	6,386,500.00	11,136,200.00
35420	Аж ахуйн материал	48,905,841.20	62,927,072.20
35430	Сэлбэг хэрэгсэл	5,861,227.00	2,404,000.00
35440	Түлш, шатах тослох материал	1,417,864.00	10,386,321.00
35470	Бусад хангамжийн материал	13,010,230.00	13,195,730.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>7,484,632,233.61</u>	<u>6,856,617,316.78</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,484,632,233.61	6,856,617,316.78
392	Биет хөрөнгө	7,135,278,038.92	6,502,996,566.78
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,140,771,430.00	2,048,602,144.50
39202	Хуримтлагдсан элэгдэл	-5,548,820.30	-70,760,627.89
39203	Авто-тээврийн хэрэгсэл	137,334,800.00	137,334,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-72,719,272.04	-84,620,072.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	166,749,286.44	164,954,434.48
39206	Хуримтлагдсан элэгдэл	-119,970,686.17	-119,651,085.91
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	104,943,954.64	108,508,880.64
39208	Хуримтлагдсан элэгдэл	-49,398,718.91	-55,621,094.72
39209	Зам, гүүрийн байгууламж	2,568,617,697.00	2,630,537,204.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-50,123,524.92	-322,214,293.30
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,971,809,401.55	2,971,809,401.55
39215	Хуримтлагдсан элэгдэл	-659,057,708.37	-907,753,324.57
39217	Ном	1,870,200.00	1,870,200.00
393	Биет бус хөрөнгө	349,354,194.69	353,620,750.00
39301	Програм хангамж	13,764,000.00	13,764,000.00

Сайншанд сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

39302	Хуримтлагдсан элэгдэл	-8,475,805.31	-13,585,250.00
39303	Бусад биет бус хөрөнгө	344,616,000.00	353,992,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-550,000.00	-550,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>7,683,378,166.31</u>	<u>7,108,006,769.48</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>3,331,547.04</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	3,331,547.04
413	Өглөг	00.00	3,331,547.04
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	3,331,547.04
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>7,683,378,166.31</u>	<u>7,104,675,222.44</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	7,683,378,166.31	7,104,675,222.44
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	593,513,848.97	593,513,848.97
51101	Өмч: - төрийн	593,513,848.97	593,513,848.97
512	Хуримтлагдсан үр дүн	6,666,349,684.92	6,090,949,691.35
51210	Өмнөх үеийн үр дүн	6,666,349,684.92	6,669,652,635.22
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-578,702,943.87
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	423,514,632.42	420,211,682.12
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>7,683,378,166.31</u>	<u>7,108,006,769.48</u>

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,935,627,935.00	1,737,501,841.73
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,941,674,799.00	561,413,065.73
120	Нийтлэг татварын бус орлого	1,941,674,799.00	561,413,065.73
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,941,674,799.00	561,413,065.73
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,642,000.00	4,144,026.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,925,032,799.00	557,269,039.73
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	993,953,136.00	1,176,088,776.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	101,622,066.00	165,139,876.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,359,019.00	444,252.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	39,760,000.00	3,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	48,983,147.00	128,206,735.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	11,519,900.00	33,488,889.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	892,331,070.00	1,010,948,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	892,331,070.00	1,010,948,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,758,316,671.58	2,171,472,939.07
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,758,316,671.58	2,171,472,939.07
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,706,649,137.34	2,120,842,967.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	580,590,815.00	608,624,519.81
210101	Үндсэн цалин	454,859,889.00	526,957,404.81
210105	Гэрээт ажлын хөлс	125,730,926.00	81,667,115.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,389,544.00	76,774,775.00
210201	Тэтгэврийн даатгал	53,799,401.00	46,433,825.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,926,767.00	12,723,414.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,658,459.00	6,201,659.00
210204	Ажилгүйдлийн даатгал	731,691.00	2,328,691.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,273,226.00	9,087,186.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,474,521.60	62,920,792.57
210301	Гэрэл, цахилгаан	6,605,357.00	6,815,129.57
210302	Түлш, халаалт	29,225,136.60	48,813,574.00
210303	Цэвэр, бохир ус	3,874,727.00	7,292,089.00
2104	Хангамж, бараа материалын зардал	157,968,315.71	105,028,085.77
210401	Бичиг хэрэг	19,337,770.00	12,557,690.00
210402	Тээвэр, шатахуун	41,236,455.00	23,330,047.00

Сайншанд сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,013,244.04	13,175,887.77
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	65,482,056.00	55,724,461.00
2105	Нормативт зардал	00.00	400,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	400,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,665,725.00	422,098,576.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	190,000.00
210604	Урсгал засвар	4,665,725.00	421,908,576.00
2107	Томилолт, зочны зардал	2,515,200.00	5,250,662.00
210702	Дотоод албан томилолт	2,408,700.00	5,250,662.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	89,473,985.12	167,781,391.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	88,849,385.12	167,158,771.00
210803	Даатгалын үйлчилгээ	215,000.00	406,020.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	162,600.00	162,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	11,000.00	54,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	755,571,030.91	671,964,165.03
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	29,798,624.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	2,752,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	755,571,030.91	639,413,041.03
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	51,667,534.24	50,629,971.89
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,370,000.00	3,293,648.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	100,000.00	719,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	2,574,648.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	47,336,323.89
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	47,336,323.89
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>1,177,311,263.42</u>	<u>-433,971,097.34</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,789,820,974.53	144,731,846.53
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,409,852,270.14	144,731,846.53
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-2,789,820,974.53	-144,731,846.53
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-1,612,509,711.11</u>	<u>-578,702,943.87</u>

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,019,692,836.00</u>	<u>1,149,027,013.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16,642,000.00	4,144,026.00
120	Нийтлэг татварын бус орлого	16,642,000.00	4,144,026.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	16,642,000.00	4,144,026.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,642,000.00	4,144,026.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,003,050,836.00	1,144,882,987.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	110,719,766.00	133,934,087.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,359,019.00	444,252.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	39,760,000.00	3,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	48,983,147.00	128,206,735.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	20,617,600.00	2,283,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	892,331,070.00	1,010,948,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	892,331,070.00	1,010,948,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>979,598,479.00</u>	<u>1,143,225,943.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	979,598,479.00	1,143,225,943.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	926,777,101.76	1,092,369,319.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	580,590,815.00	605,240,982.77
210101	Үндсэн цалин	438,588,555.00	467,951,560.77
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	374,584.00
210105	Гэрээт ажлын хөлс	141,604,760.00	136,914,838.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	71,287,684.00	76,230,775.00
210201	Тэтгэврийн даатгал	47,525,123.00	52,479,075.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,940,640.00	4,750,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,752,512.00	5,938,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,188,128.00	1,187,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,881,281.00	11,875,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,474,521.60	62,920,792.57
210301	Гэрэл, цахилгаан	6,570,513.00	6,815,129.57
210302	Түлш, халаалт	29,297,457.60	48,813,574.00
210303	Цэвэр, бохир ус	3,837,250.00	7,292,089.00
2104	Хангамж, бараа материалын зардал	55,040,388.14	71,018,854.77

Сайншанд сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210401	Бичиг хэрэг	15,303,768.00	18,809,500.00
210402	Тээвэр, шатахуун	24,874,460.00	26,300,952.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,974,595.14	13,192,087.77
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,647,565.00	12,476,315.00
2105	Нормативт зардал	400,000.00	1,900,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	400,000.00	1,900,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,500,000.00	16,105,340.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	377,000.00
210604	Урсгал засвар	10,500,000.00	15,728,340.00
2107	Томилолт, зочны зардал	2,515,200.00	5,250,662.00
210702	Дотоод албан томилолт	2,515,200.00	5,250,662.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	157,968,493.02	219,953,788.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	157,343,893.02	218,895,168.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	236,000.00	436,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	215,000.00	406,020.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	162,600.00	162,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	11,000.00	54,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	33,748,124.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	30,798,624.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	2,949,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	52,821,377.24	50,856,623.89
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,088,243.00	3,520,300.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	818,243.00	719,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	2,801,300.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	435,600.00	47,336,323.89
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	435,600.00	47,336,323.89
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>40,094,357.00</u>	<u>5,801,070.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	26,134,600.00	8,831,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	26,134,600.00	8,831,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	26,134,600.00	8,831,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	26,134,600.00	8,831,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-26,134,600.00</u>	<u>-8,831,000.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	13,959,757.00	-3,029,930.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	13,959,757.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	13,959,757.00	10,929,827.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	249,447,848.97	8,863,022.11	8,278,859,396.03	8,537,170,267.11
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	249,447,848.97	8,863,022.11	8,278,859,396.03	8,537,170,267.11
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	344,066,000.00	00.00	-1,612,509,711.11	-1,268,443,711.11
2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	593,513,848.97	423,514,632.42	6,666,349,684.92	7,683,378,166.31
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	593,513,848.97	423,514,632.42	6,666,349,684.92	7,683,378,166.31
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	3,302,950.30	3,302,950.30
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	593,513,848.97	423,514,632.42	6,669,652,635.22	7,686,681,116.61
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-3,302,950.30	00.00	-3,302,950.30
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-578,702,943.87	-578,702,943.87
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	593,513,848.97	420,211,682.12	6,090,949,691.35	7,104,675,222.44

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,011,948,900.00	1,015,092,926.00	-3,144,026.00	100.31
УРСГАЛ ЗАРДАЛ	1,011,948,900.00	1,015,092,926.00	-3,144,026.00	100.31
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,009,848,900.00	997,297,991.11	12,550,908.89	98.76
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	587,980,500.00	582,398,597.77	5,581,902.23	99.05
Үндсэн цалин	441,100,500.00	445,109,175.77	-4,008,675.77	100.91
Унаа хоолны хөнгөлөлт	00.00	374,584.00	-374,584.00	
Гэрээт ажлын хөлс	146,880,000.00	136,914,838.00	9,965,162.00	93.22
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	73,497,600.00	73,497,600.00	0.00	100.00
Тэтгэврийн даатгал	49,745,900.00	49,745,900.00	0.00	100.00
Тэтгэмжийн даатгал	4,750,100.00	4,750,100.00	0.00	100.00
ҮОМШӨ-ний даатгал	5,938,500.00	5,938,500.00	0.00	100.00
Ажилгүйдлийн даатгал	1,187,200.00	1,187,200.00	0.00	100.00
Эрүүл мэндийн даатгал	11,875,900.00	11,875,900.00	0.00	100.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	68,559,900.00	62,920,792.57	5,639,107.43	91.77
Гэрэл, цахилгаан	7,112,500.00	6,815,129.57	297,370.43	95.82
Түлш, халаалт	53,398,400.00	48,813,574.00	4,584,826.00	91.41
Цэвэр, бохир ус	8,049,000.00	7,292,089.00	756,911.00	90.60
Хангамж, бараа материалын зардал	70,735,900.00	70,694,602.77	41,297.23	99.94
Бичиг хэрэг	18,150,000.00	18,809,500.00	-659,500.00	103.63
Тээвэр, шатахуун	26,159,700.00	25,976,700.00	183,000.00	99.30
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,751,200.00	13,192,087.77	559,112.23	95.93
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00	0.00	100.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,435,000.00	12,476,315.00	-41,315.00	100.33
Нормативт зардал	400,000.00	400,000.00	0.00	100.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	400,000.00	400,000.00	0.00	100.00

Сайншанд сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Эд хогшил, урсгал засварын зардал	25,150,000.00	24,936,340.00	213,660.00	99.15
Багаж, техник, хэрэгсэл	9,900,000.00	9,208,000.00	692,000.00	93.01
Урсгал засвар	15,250,000.00	15,728,340.00	-478,340.00	103.14
Томилолт, зочны зардал	5,074,000.00	4,735,300.00	338,700.00	93.32
Дотоод албан томилолт	5,074,000.00	4,735,300.00	338,700.00	93.32
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	176,001,000.00	175,265,258.00	735,742.00	99.58
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	174,500,000.00	174,206,638.00	293,362.00	99.83
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	436,000.00	436,000.00	0.00	100.00
Даатгалын үйлчилгээ	525,000.00	406,020.00	118,980.00	77.34
Тээврийн хэрэгслийн татвар	450,000.00	162,600.00	287,400.00	36.13
Тээврийн хэрэгслийн оношлогоо	90,000.00	54,000.00	36,000.00	60.00
Бараа үйлчилгээний бусад зардал	2450000.00	2449500.00	500.00	99.98
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,450,000.00	2,449,500.00	500.00	99.98
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2100000.00	2100000.00	0.00	100.00
Бусад урсгал шилжүүлэг	2,100,000.00	2,100,000.00	0.00	100.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,100,000.00	2,100,000.00	0.00	100.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,011,948,900.00	1,015,092,926.00	-3,144,026.00	100.31
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,010,948,900.00	1,010,948,900.00	0.00	100.00
Орон нутгийн төсвөөс	1,010,948,900.00	1,010,948,900.00	0.00	100.00
Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих			0.00	
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,000,000.00	4,144,026.00	-3,144,026.00	414.40
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	4,144,026.00	-3,144,026.00	414.40
АЖИЛЛАГСАДЫН ТОО	89.00	89.00	0.00	100.00
Удирдах ажилтан	09.00	09.00	0.00	100.00
Гүйцэтгэх ажилтан	28.00	28.00	0.00	100.00
Үйлчлэх ажилтан	16.00	16.00	0.00	100.00
Гэрээт ажилтан	36.00	36.00	0.00	100.00

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		136,964,017.00
УРСГАЛ ЗАРДАЛ		136,964,017.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		103,902,328.00
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		22,842,385.00
Үндсэн цалин		22,842,385.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		2,733,175.00
Тэтгэврийн даатгал		2,733,175.00
Хангамж, бараа материалын зардал		324,252.00
Тээвэр, шатахуун		324,252.00
Нормативт зардал		1,500,000.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл		1,500,000.00
Томилолт, зочны зардал		515,362.00
Дотоод албан томилолт		515,362.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		44,688,530.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		44,688,530.00
Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	31298624.00
Бараа үйлчилгээний бусад зардал		30,798,624.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		500,000.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	1420300.00
Бусад урсгал шилжүүлэг		1,420,300.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		719,000.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		701,300.00
Олгосон санхүүжилт, шилжүүлэг		31,641,389.00
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг		31,641,389.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	133934087.00
Нэмэлт санхүүжилтийн орлого		133,934,087.00
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		444,252.00
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		3,000,000.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		128,206,735.00

Сайншанд сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		2,283,100.00
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		